

Зөвлөх сонгон шалгаруулах тухай

2017 оны 4 дүгээр сарын 26

Улаанбаатар хот

Зорилго: Үндэсний аудитын газрын хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулах үйл явцыг сайжруулах зорилгоор хувийн аудитын компанийтай гэрээ байгуулахаар сонгон шалгаруулалт хийх үйл явцыг илүү үр дүнтэй, ил тод болгож баримтжуулах чиглэлд техникийн туслалцаа үзүүлэх ба хараат бус аудитын компанийг бүрэн ил тод, үр дүнтэй гэрээлэхэд баримтлах журмын төслийг боловсруулах

ЗӨВЛӨХД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Боловсрол:

- Нягтлан бодох, аудит болон бусад холбогдох чиглэлээр их дээд сургууль төгссөн байх;

Ажлын туршлага:

- аудит хийж байсан туршлагатай байх /5-аас дээш жил /;
- судалгаа шинжилгээ хийх түвшний Англи хэлний мэдлэгтэй байх;
- судалгаа, шинжилгээ хийх арга зүй, арга хандлагын талаар ойлголт, мэдлэгтэй байх;
- аудитын дээд байгууллагад гэрээлэх болон хувийн аудитын компанийтай гэрээ байгуулах чиглэлээр ажиллаж байсан бол түүний давуу тал болно;
- аудитын чанарын баталгаажуулалтын чиглэлээр ажиллаж байсан бол давуу талтай;
- худалдан авах үйл ажиллагааны талаар мэдлэгтэй ба тодорхой хэмжээний аудитын туршлага (5 жил ба түүнээс дээш) хосолсон бол давуу тал болно.

Бусад ур чадвар: Багаар хамтран ажиллах чадвартай байх, өндөр хариуцлагатай хянамгай ажиллах;

Зөвлөх нь худалдан авах үйл ажиллагааны явц болон арга хандлагын талаар зохих түвшний мэдлэгтэй байна. Аудитын чанарын гол хүчин зүйлүүдийн талаар гүн гүнзгий мэдлэгтэй байх ёстойгоос гадна боловсруулсан гэрээлэхэд баримтлах журмын төсөлд тус элементүүдийг тусгасан байна.

Гэрээний хугацаа: 2017 оны 5 дугаар сараас эхлэн 2 сарын хугацаанд гүйцэтгэнэ.

Шаардлага хангасан хүмүүс 2017 оны 4 дүгээр сарын 28-ны 8:30 цагаас өмнө өөрийн анкет, ажлын туршлагын талаарх мэдээлэл /CV/-ийг nurzedl@audit.gov.mn хаягаар ирүүлнэ үү. Дэлгэрэнгүй мэдээллийг 51-262071 дугаарын утсаар холбогдож авна уу.

Үндэсний аудитын газар